



WWF

BOOK

MNG

2012

МОН ДАГАЖ УС, УС ДАГАЖ АМЬДРАЛ

УЛААНБААТАР 2012

DDC
155.413
Б - 33

МОД ДАГАЖ УС, УС ДАГАЖ АМЬДРАЛ

Зохиолыг: Ембүүгийн Батчулуун
Зургийг: Г.Амарсанаа
Хянасан: М.Хулан
Эх бэлтгэсэн: Х.Балдандорж

ISBN: 978-99962-3-397-5

ГАРЧИГ

Унасан газар, угаасан ус минь	5
Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад миний хувь нэмэр	7
Хүлэмжийн хий гэж юу вэ?	9
Голын сав газар	15
Намаг-байгаль дэлхийн өгөөж	21
Бэлчээрийн менежмент гэж юу вэ?	24
Татмын ой ямар ач холбогдолтой вэ?	27
Заг зандангаас үнэтэй	33
Мод дагаж ус, ус дагаж амьдрал	38

ӨМНӨХ ҮГ

Уур амьсгал дулаарч, хүйтрэх нь олон жилийн давтамжтай байгалийн үзэгдэл хэдий ч үүнд хүний үйл ажиллагаа ихээр нөлөөлдөг нь нэгэнт батлагдаад байна. Дулаарлыг бууруулах гол арга зам нь дэвшилтэт технологи гэхээсээ илүү олон нийтийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх явдал бөгөөд үүнд хүн бүрийн хувь нэмэр асар чухал.

Уур амьсгалын дулаарлын улмаас байгалийн гамшигт үзэгдлийн давтамж нэмэгдсээр байна. Үүний нэг тод илрэл нь 2010 онд Гайтид болсон хүчтэй газар хөдлөлт, 2011 онд Исландад болсон галт уулын дэлбэрэлт, 2011 оны 3 дугаар сарын 11-нд Японд цунами болж олон мянган хүний амь нас сүйдээд зогсоогүй цөмийн аюул зэрэг дагалдсан хор уршиг нь дэлхий нийтийг цочроосон билээ.

Манай орны хувьд галт уулын дэлбэрэлт зэрэг аюулаас хол боловч хүчтэй салхи шуурга үүсэх, ой хээрийн түймэр дэгдэх, гол ус үерлэх зэрэг аюулт үзэгдлийн давтамж нэмэгдсээр байна. Түүнчлэн хур бороо орохгүй ган гачиг үргэлжлэх, гол нуурын ус ширгэх, бэлчээрийн талбай, сум суурин газрууд хүртэл элсний нүүлтэд нэрвэгдэх зэрэг үзэгдэл ч ихсэж, улмаар хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байна. Энэ бүхнээс урьдчилан сэргийлэх, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг сааруулах, үүнд дасан зохицож амьдрах гол арга зам нь энэ талаархи мэдлэгээ дээшлүүлэх явдал юм.

Иймд уур амьсгалын өөрчлөлт, нөлөөлөх хүчин зүйлийн талаар олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх үүднээс “Мод дагаж ус, ус дагаж амьдрал” гэсэн энэхүү товхимлыг бэлтгэн гаргаж байна.

Та бүхний санал хүсэлтийг бид талархан хүлээн авах бөгөөд Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газрын нэр дээр ирүүлнэ үү.

Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар

УНАСАН ГАЗАР, УГААСАН УС МИНЬ

Миний багын найз Долгор хөдөө суманд мал маллаад сайхан амьдардаг нэгэн. Бид багадаа сумынхаа бага сургуульд нэг ангид сурч байсан юм. Саяхан нутгаараа очихдоо Долгорынд зочилж багын явдал, ангийн андуудынхаа талаар бараг шөнөжин хууч хөөрлөө.

Долгор дээхэн үед гаталга өгдөггүй байсан голын ус татраад ширгэх шахсан, төгсөх ангийнхаа шалгалтад бэлдэх нэрээр хамтдаа шуугилдан хөрвөөдөг байсан сайхан зүлэгтэй тохой одоо бараг алга болсон, намар хичээл эхэлсний дараахан хүүхэд болгон шүүр хийх сургуулийн даалгаврыг биелүүлэхэд гол “үүрэг гүйцэтгэдэг” байсан өндөр дэрс ч устсан тухай ярив. Би Долгорыг арай ч дэгсдүүлж байгаа биз гэж бодон хэвтлээ. Ингэж бодохоос ч аргагүй, тэр дэрсний дунд тэмээ ороход харагддаггүй байсан юм чинь. Тэмээг бараг 2 метр орчим гэж бодоход, тэгээд ч тэр үеэс хойш 20 гаруйхан жил өнгөрсөн гэхээр миний итгэхгүй байх нь ч аргагүй шүү дээ. Долгор ч миний эргэлзээд байгааг гадарласан бололтой, маргааш багын “тоглоомын талбай”-гаа эргэх явцдаа надад энэ бүхнийг үзүүлнэ хэмээлээ.



Нээрээ л маргааш нь би өссөн намаржаа руугаа явахдаа Долгорын яриа үнэн байсныг мэдлээ. Харамсалтай санагдав. Зун ус ихэдсэн үед эрэг дээр нь тракторчин Нямаа гуай байнга л “жижүүрлэдэг” байсан бол одоо багачууд хээвнэг ус цацалцан “гол дотор” тоглоно. Хэдэн үхэр, адуу шавартай усыг голсон бололтой хааяа нэгхэн уух аядан санаа дагаад ч тэр үү гунигтайхан, “та хар даа” гэсэн шиг бээвийн зогсоно. Байсхийгээд л усанд автдаг, дараа нь шараар будсан мэт цэцгээр бүрхэгддэг байсан татам нь нарийсаад “шавран татам” болжээ.

Долгор ч миний санааг ойлгов бололтой, “Уур амьсгал дулаараад л байгаа юм гэсэн шүү дээ, тэгээд бороо орох нь ч багасаж. Бид ч юу хийж чадах билээ?” хэмээн их л гэмшингүй хэлж байна. Би түүнийг цаашлуулах санаатай “Чи ч энд буруутай ш дээ” гэхив. Нөгөөх чинь тас тас хөхөрч байна. “Би буруутай гэнээ? Тэхээр манай энэ голынхон чинь бүгд л буруутай болж таарах нь ээ. Энэ голд төрчихөөд хаяад явчихсанаараа чи тэгээд яахав?” гэж байна. Энэ үг надад толгой дундуур татах шиг болов. “Нээрээ би орон нутагтаа юу хийж, ямар хувь нэмэр оруулсан билээ” гэж бодлоо. Тэгээд би “Уур амьсгалын дулаарлыг сааруулахад чиний хувь нэмэр ч багадахгүй” гэж Долгорт хэллээ. Долгор нүдээ том болгож “Би нээрээ хувь нэмэр оруулж чадах юмуу, манай голынхон лав үүнийг мэдэхгүй дээ” гэж байна. “Чи чаднаа Долгор минь. Би чамд тусална.”

Ингээд би нутгийнхаа олонтой нийлж хэсэг хугацаанд ажиллахаар болсон билээ.

УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙГ СААРУУЛАХАД МИНИЙ ХУВЬ НЭМЭР

Долгор бид хоёр манай голынхныг цуглуулж ярилцахаас ажлаа эхэллээ. Биднийг зорилгоо тайлбарласны дараа хүмүүсийн идэвхи илт сэргэж асууж эхлэв.



“Уур амьсгал өөрчлөгдөж байна, дулаарч байна, энэ нь ийм, тийм хор хохиролтой хэмээн хаа сайгүй л ярьдаг болж. Энэ чинь байгалиасаа л болж байгаа биш юм уу, энэнд малчид бид юуны хамаа байнаа? Манайх шиг хүйтэн газар дулаарч л байвал сайн биш үү гэж бодогдох юм. Цаг агаар, уур амьсгал гэдэг чинь ямар ялгаатай юм бэ? Надад нэг сайн ойлгуулаад өгөөч?”

Бид “Өчигдөр ч мөддөө тасрахгүй дээ гэмээр их бороо орж байсан чинь өглөө нар тусаад өнөөдөр ч сайхан өдөр болох нь ээ” гэлцдэг шүү дээ. Эсвэл хөгшид “маргааш тэнгэр нэг л бишдэх нь, сар хүрээлж хоносон байна шүү” хэмээн тэнгэрийг шинжинэ. Өчигдөр өнөөдөр, маргааш зэрэг цөөн хоногийн тэнгэрийн “араншин”- г цаг агаар гэдэг. Харин “энэ зун их хуурай, гандуу байна шүү, өвөл өнтэй сайхан боллоо” хэмээн ярилцах нь уур амьсгалын тухай ярьж байгаа хэрэг юм. Ингэхлээр цаг агаар гэдэг нь богино хугацааны агаарын төлөв байдлыг хэлдэг бол уур амьсгал нь цаг агаарын олон жилийн төлөв байдал юм.



“Цаг агаар ба уур амьсгалын ялгааг мэдэж авлаа. Харин дулаарлын талаар тайлбарлаж өгөөч. Дулаараад л байгаа гэх юм, нээрээ ч үнэн шүү. Биднийг бага байхад айхтар хүйтэн өвөл болдог байсан шиг санагдана. Энэ чинь 30-40 жилийн өмнө шүү дээ. Үнэгэн малгай бүслээд л явдаг сан. Одоо үнэгэн малгай өмсөх хүн ч үгүй болж, хэрэв өмсвөл халууцаад сүйд болох маягтай даг шүү. Зундаа нэлээд сэрүүхэн болчихсон юмуу даа. Тэгсэн хэрнээ цөөн хэд хоног бүр шатах шахам халахыг нь яанаа. Дээхэн үед бол налайсан сайхан урт зун болдог байсан санагдана. Энэ үнэн биз, ингэхэд би өөрөө уур амьсгал хэрхэн өөрчлөгдөөд байгааг бүр баримттайгаар ярьчихав уу даа”

Та нар зөв ажиглажээ. Сүүлийн хорь гаруй жилийн хугацаанд уур амьсгалын өөрчлөлт мэдэгдэхүйц болж, энэ нь дэлхийн хэмжээний асуудал болж байна. Зун богино болжээ гэлцэх боловч богино хугацаанд хэт халах нь нэмэгдэж байна. Манай орны хувьд гэхэд л өнгөрсөн 70-аад жилийн дотор дунджаар 2.14 орчим хэмээр дулаарсан нь дэлхийн дунджаас 3 дахин эрчтэй дулаарч байна.

Хүлэмжийн хий гэж юу вэ?

“Хүлэмжийн хий гэж их ярих болж. Гэхдээ малчид бид чинь үүнийг сайн ойлгохгүй юмаа. Манай урд хашааны “гүйдэг” Буянаа л ажилсаг хүн болохоороо хашаандаа хүлэмж бариад биднийгээ ямар сайхан улаан лооль, өргөст хэмхээр дайлдаг гээч. Би нэг удаа түүнд туслах санаатай дотор нь ортол тэсэхийн аргагүй халуун бүгчим юм билээ. Аргагүй “гүйдэг” маань л тэсдэг юм байлгүй дээ” гэж Нямаа гайхан өгүүлэв.

“Нямаа минь, хүлэмж дотор яагаад тийм халуун бүгчим байдаг гэж бодож байна даа?”

“Гадуур нь нэлдээ гялгар цаасаар битүүлчихсэн юм чинь аргагүй шүү дээ, нарны илчийн туслалцаатайгаар гаднаасаа дулаанаа авчихна. Гэхдээ агаар салхи орохгүй. Тэгээд л тэр байхгүй юу. Дорж гуайнх бас хүлэмж хийсэн. Тэднийх болохоор нэлдээ шил байж харагдсан шүү. Шил аягүй бол гялгар цааснаас ч илүү хална шүү дээ. Тэдний хүлэмж бол бүүр ч бүгчим халуун байгаа даа.”

Нямаагийн ажигласнаар бол хүлэмжийг хийсэн гялгар цаас болон шилээр нарны гэрэл нэвтэрч дотроо халдаг байна шүү дээ. Тэгээд дулаанаа хадгалдаг тул дотроо халуун байдаг байна. Тэгвэл агаарт байдаг зарим хий эгээ л гялгар цаастай адилхан дулааныг тогтоон барьдаг юм. Угтаа бол нарнаас ирж байгаа дулаан нь газрыг халаасны дараа эргэн гарч тэнцвэртэй байдалд орох ёстой л доо. Гэтэл энэ тэнцвэр нь агаар бохирдсон үед алдагддаг. Ийм болохоор нь “хүлэмжийн хий” гэж нэрлэдэг.



“Аа за, ойлголоо. Халуун өдөр гадаа тавьсан машин дотор ч айхтар халсан байдаг шүү дээ. Бушуухан л цонхоо онгойлгохгүй бол бүтэж үхлээ л гэсэн үг шүү” гэж “баян” Болд хэлэв.



“Хүлэмжийн хийд намгийн хий, усны уур, азотын ислүүдээс гадна нүүрсхүчлийн хий орно. Та нар энэ талаар мэдэх үү?”

“Наадахыг чинь бол харин гадарлах юм байна шүү. Нүүрсний дутуу шаталтаас угаарын хий үүсдэг. Нүүрс түлэхээр үнэртдэг дээ. Энэ нь хүчилтөрөгчтэй нэгдэж хүлэмжийн хийн гол бүрэлдэхүүн болох нүүрсхүчлийн хийг үүсгэдэг. Харин намгийн хий хүн, амьтны ялгадаснаас гардаг гэдэг.”





“Нээрээ л манай сумынхан Гомбодорж багшийнхаа ачаар химийн хичээлдээ их сайн байсан шүү. За тэхээр хүлэмжийн хий агаарт ямар замаар нэмэгддэг нь тодорхой боллоо, тийм ээ!”

“За хүүхэд минь нүүрсээ багасга, цацдаг, шүршдэг юмнуудаа бүү хэрэглэ гэсэн үг дээ!” гэж Дулмаа хөхрөв.



“Ер нь бол тийм шүү. Агаарын бохирдол ихсэхэд хүлэмжийн хий ихсэнэ. Ингэхлээр газрын гадарга орчмын агаар дулаарах нь аргагүй гэдгийг бид мэдэж авлаа. Тэгэхээр дулаарахад бид ч гэсэн нөлөө үзүүлж байна уу?” гэхэд хүмүүс бүгд толгой дохив. Би нэг ч гэсэн зүйлийг ойлгуулж чадсандаа баяртай байлаа.

“Бас нэг аюултай хий бий. Энэ нь диоксин гэдэг. Ялангуяа машины дугуй, ундааны сав зэргийг шатаахад энэ хий ялгардаг” гэж намайг ярьж эхлэнгүүт Нямаа тосож аваад:

“Агаарыг бохирдуулаад байгаа энэ олон хийг багасгахад би ч нэмэр болж чадах юм байна. Юу гээч? Өнөөдрөөс эхлээд ундааны савыг галдаа хийхээ лав зогсооно гэхэд хүмүүс инээлдэн, нээрээ л тийм дээ” гэгцгээв.

Би ч урамшин “Хүлэмжийн хийг багасгахын тулд та нар үүнээс ч илүү зүйлийг хийж чадна” гэв. Хүмүүс гайхан харж байна. “За тэгвэл үүнийг уншаад сайтар эрэгцүүлэн бодоорой” гэж хэлээд хувилж олшруулсан материалаа тарааж өглөө. Алив нааш нь, алив надаа нэг гэсээр хүмүүс шуугилдан уншиж эхэллээ. Та ч бас бидэнтэй хамт уншаарай.

Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах гэдэг нь үүнийг үүсгэж буй шалтгааныг арилгах арга хэмжээ авахыг хэлнэ.

Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад таны оролцоо хамгаас чухал. Дараахь зүйлсийг бид амьдралдаа хэвшүүлж сурвал та хувь нэмрээ оруулж байгаа гэсэн үг юм. Үүнд:



1. Хашаа хороогоо зүлэгжүүлж, мод, цэцэг тарих

Зөвхөн ганц мод таривал тэр нь амьдрах хугацааныхаа туршид 1 тонн нүүрсхүчлийн хийг өөртөө шингээдэг байна.



2. Аль болох явган явах юмуу ердийн хөсөг хэрэглэх:

Ингэвэл 1.6 км буюу холхон саахалт айл хэртэй явах бүрт 0.5 кг нүүрсхүчлийн хий агаарт ялгарахаас сэргийлж чадна. Явган явах нь эрүүл мэндэд сайнаас гадна зардал хэмнэнэ шүү дээ.



3. Нийтийн тээврээр зорчих

Нэг литр бензин ашиглах тутамд 2.5 кг нүүрсхүчлийн хий ялгаруулдаг байна. Тэгвэл өдөрт дунджаар 10 литр бензин ашигладаг гэж бодвол 25 кг нүүрсхүчлийн хий ялгаруулах нь байна шүү дээ. Хэрэв нийтийн тээврээр үйлчлүүлбэл агаарт олон мянган кг нүүрсхүчлийн хий ялгарахыг бууруулж чадах нь байна.



4. Гэрлийн чийдэнгээ солих

Улайсаж асдаг ердийн чийдэнгээ өдрийн гэрлээр солиход жилдээ 68.1 кг нүүрсхүчлийн хий ялгарахаас сэргийлдэг гэсэн тооцоо бий. Наад зах нь та цахилгааны зардлаа ч хэмнэнэ гэдгийг анхаараарай.



5. Цахилгаанаа бүрэн унтраах

Зурагт, хөргөгч, хөгжим, компьютер зэрэг цахилгаан “иддэг” хэрэгслийг ашиглаагүй үедээ залгуурыг нь салгаж бүрэн унтрааж байвал нүүрсхүчлийн хий агаарт ялгарахаас сэрийлж чадна.



6. Сэргээгдэх эрчим хүчийг хэрэглэх

Нар, салхи зэрэг байгалийн цахилгаан үүсвэрийг ашигладаг бол та уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад бодитой хувь нэмэр оруулж байгаа юм. Жишээ нь, манай малчид нарны зайгаар ажилладаг хэрэгсэл ашигладаг.




7. Өвөлд бэлдэж, гэр орноо сайн дулаалах

Хэрэв өвлийн улиралд гэрээ сайн дулаалж халаагуурын хэмийг 1-ээр буруулахад өрхийн бүтэн жилийн цахилгааны зардлыг 5-10 хувиар хэмнэхээс гадна агаарт 300 кг нүүрсхүчлийн хий ялгарахаас сэргийлж чадна. Ингэхлээр гэр орон, цонх, хаалгаа сайн дулаалснаар дулаан алдагдлыг бууруулж уур амьсгалын өөрчлөлттэй бодитой тэмцэж байна гэсэн үг юм.

8. Мал сүргийг зөв бүтэцтэйгээр өсгөх

Мал сүргийг зөв бүтэцтэйгээр өсгөснөөр агаарт хаягдах олон мянган тонн хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулж чадна. Ингэснээр хөрсний эвдрэл, бэлчээрийн доройтол ургамлын төрөл зүйл цөөрөхөөс сэргийлнэ.



9. Хог хаягдлаа багасгах, дахин боловсруулах

Хогийг ялгаж сурах, хаягдал бөс даавуу, цаас зэргийг дахин ашиглаж ариг гамтай амьдарч сурах нь нүүрсхүчлийн хийг бууруулахад хувь нэмрээ оруулж байгаа нэг хэлбэр мөн. Түүгээр ч зогсохгүй хоолны үлдэгдэл, малын баас зэргийг дарж нягтруулан дарш бэлдэх замаар ногооны талбайдаа “бэлэн бордоо” бэлдэх боломжтой.



10. Нэг удаагийн сав, боодол хэрэглэхгүй байх

Бидний нэрлэж заншсанаар гарын ая даахгүй гялгар уут, сав хэрэглэхээс аль болох татгалзаж, даавуун уут, баадан зэргийг хэрэглэж сурвал уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хувь нэмрээ оруулж байгаа хэрэг юм. Жишээ нь, нэг жилд хэрэглэх нийлэг уутны хаягдлыг 10 –хан хувиар л бууруулбал 500 гаруй кг нүүрсхүчлийн хий агаарт ялгарахаас сэргийлж чаддаг ажээ.


УНШИГЧ ТАНД ЯМАР САНАГДАВ? ТА Ч ГЭСЭН УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙГ СААРУУЛАХАД ХУВЬ НЭМЭР ОРУУЛЖ ЧАДАХААР БАЙГАА БИЗ!

ГОЛЫН САВ ГАЗАР

Манай голынхон хэзээний эх оронч улс. Яагаад гэвэл, жилийн дөрвөн улиралд голоо өгсөж уруудаад л нүүхээс өөр газар идээшнэ гэж байхгүй. Миний багад нэлээд хижээлдүү юм шиг харагддаг байсан Дампил гуай одоо ч хэвлүүхэн харагдана. Үс нь бууралтсанаас өөр хөгширчээ гэмээр зүйлгүй Дампил гуай тэр үед идэр эр байж дээ. Өтөл буурал болтлоо цөөн хэдэн удаа л аймгийн төв орсон байх шүү, дээр үед цэрэгт алба хаахдаа л нутгаасаа гарсан гэдэг юм.

Сүүлийн хэдэн жил Дампил гуай голын сав газрын зөвлөлийн идэвхтэй гишүүн болжээ. Энэ нь өвгөнд сайхан зугаатай ажил болж, айл амьтнаар орж аяга тагш юм эргүүлдэг байснаа ч больж, харин түүний оронд ухуулга хийж, энэ тэрийг зааварлаж явдаг ажилтай болжээ. Эхнэр хүүхнүүд хүртэл Дампил гуайг зөвлөлийн гишүүн болсноосоо хойш өнгө зүс орж, залуу хүн шиг дуу аялан морин дэл дээр давхиж явдаг болсон гэж цаашлуулна. Нээрээ л зундаа хүрэн, өвөлдөө ногоон үстэй дээлнээс салдаггүй байснаа больж, бүүр нэг албаны хүн шиг царайлан ээтэн гутлынхаа оронд хар хром жийжээ. Ажил хөдөлмөр гэж настай хүнийг ч гэсэн ингэж өөд татдаг байна шүү.

“Хүүхээд...” гэж ирээд л ярьж гарна. Цэргээс ирснийхээ дараахан бичиг үсгийн дугуйланд хичээл зааж, бас ч үгүй багийн сургуулийн захирал хүртэл явсных, сайхан ч тайлбарлаж ярина.



“Хүүхээд, манай энэ Ховд гол чинь одоо 3 аймгийн 29 сумын нутгаар дамжин урсаж байгаа юм шүү дээ, ийм олон улс амьтныг ундаалж байгаа мөн ч агуу гол шүү” гэлээ.

Би бүр гайхаж хоцорлоо, Дампил гуай яахаараа ийм тодорхой мэддэг байнаа, би ч сайн мэдэхгүй юм байна гэж дотроо бодлоо.


“Хүүхэд, тэхээр энэ олон сумын хүн зон, за тэгээд дээр нь мал сүргийг нь нэмээд, бас болоогүй суваг шуудуу татаж ногоо цагаагаа тариалж байгаа гээд боддоо” гэв. Тэгээд үргэлжлүүлэн ярьж гарлаа. “Бид л өөрсдөө эрүүл саруул амьдраад ядаж миний насанд хүрье гэж бодож байгаа бол усаа цэвэр ариун байлгах ёстой. Сайхан машин тэрэг унаж давхиад байдаг, тэгсэн мөртлөө ус мөрөн бохирдсоноос болж наад зах нь өвчин тусна, цаад зах нь байгалийн тэнцвэр алдагдана гэдгийг мэдэхгүй бол ямар хэрэг байхав дээ” гэлээ.



“Дампил гуай, “байгалийн тэнцвэр” гэж чухам яг юуг хэлээд байнаа, тэгээд бас алдагдах аа? Манай бага хүү л эртээд гэрийн даалгавар хийж суухдаа иймэрхүү юм уншаад байсан шүү, хүүгээсээ асуухаас жаахан нэрэлхээд...” гэж Долгор тэндээс асууж байна.

“Хүүхдээсээ асуухад нэрэлхээд байх юу байсан юм. Ер нь манай зөвлөлийнхний хэлж байгаагаар бол бид чинь бүгдээрээ л хамтран ажиллах ёстой юм шүү дээ. Мэддэг нэг нь мэддэггүйдээ хэлж, мэдэхгүй нэг нь нэрэлхэхгүй асууж байх ёстой. Яагаад гэвэл голын сав газраа зохистой ашиглаж хамгаалахад хүн бүрийн хүчин зүтгэл хэрэгтэй.”

Би золтой л түс хийчихсэнгүй. Хуучин бууны хугархай гэсэн дээ бас “жанжин Сүхбаатарынхаар”-аа “залж” байна шүү. Уг нь ч зөв л дөө. Бүх хүний л хувь нэмэр оролцох ёстой гэдэг нь...





“За тэхээр Долгор чи бод доо! Ухаандаа зун намрын цагт Хар-Ус нуурын зэгсэн дотор тэмээ орчихоороо харагддаггүй байсан л даа, одоо тэхэд яаж байна, тэмээ өвсгүйдээд бүр Дөргөний доод руу алга болоод өгдөг болж. Би саяхан хоёр атаа хайгаад бүр тэндээс олж авсан. Нуурын эргээр нил хужиртай шавар. Зэгс яагаад өндөр ургах аа байв!”



“Долгор мөчөөгөө өгөхгүй санаатай Угаасаа л бороо орохгүй байгаа юм чинь дээ, дээр үед бол бороо хур ихтэй байсан болохоор тэр байхгүй юу даа!” гэлээ.



“За ингээд л бид дутуу ойлгоод байгаа юм аа. Энэ чинь зөвхөн бороо багатайгаас болоогүй ээ! Бид Ховд голынхоо усыг харъя л даа. Бороо багасаж байгаа нь ч бас биднээс болж байгаа юм.”

“Хөө ердөө, бид бороонд буруутай болж таарлаа, энэ ч арай...” хэмээн хулгар Ганбаа тачигнатал хөхрөөд эргэн тойрноо харав. Араар суугаа хэдэн охид жуумалзсанаас өөр хулгартай “нэгдэх” хүн гарсангүй. Мань хүн Дампил гуай руу гэмшингүй хараад таг боллоо. Дампил гуай ч хулгарыг ганц хяламхийж харснаас өөр тоосон ч үгүй.

“Юу ярьж байлаа? Аа тийм голын ус багассан тухай. Хүүхэд, тэхээр та хэдэд би бүүр нэг сайн тайлбарлаад өгье” гээд богцоо уудалснаа нямбайлан эвхсэн зураг гаргаад ирлээ.

Пөөх сав газрын зөвлөлийн идэвхтэй гишүүн гэдэг нь үнэн байх нь гэж би бахархан бодож суув.





“За зүйтэй, үүнд юу өгүүлсэн байна вэ?” гэлээ.

Хүмүүс хоорондоо шивэр авир гэлцэнэ. Дампил гуай ч урамшин, та нар нэг сайн хараад, ном эрдэмтэй улс байна ярилцаж бай, би нэг гаанс шүдэнээ нийлүүлэх минь гээд гарч одов.

Юутай ч хүмүүс байгаа өрөөнд тамхи татахаа больсон байна. Дампил гуай хүртэл гадаа тамхилж байхыг бодоход “тамхи татдаг хүн бусдыг хордуулдаг” гэдгийг сайн ойлгож авсан байна. Нөгөө талаар Дампил гуайн “заах арга” ч сэтгэлд нийцэв. Жинхэнэдээ бид багш нартаа л “ухуулаад” байдаг “оролцооны арга”-ыг харин Дампил гуай л үзүүлж байгаа бус уу.

Уншигч та ч гэсэн голын сав газарт амьдрахдаа анхаарах зүйлсийг сайн ажиглаарай.

НАМАГ-БАЙГАЛЬ ДЭЛХИЙ ӨГӨӨЖ



Голын сав газар дахь
намаг ашигтай юу?

Голын сав газрын тухай яриа
явсаар намгийн тухай болж өрнөлөө.
Яагаад гэвэл манай энэ хавийн гол, нуурын
эргээр намаг элбэгтэй. Зундаа бол намган дундах
довнууд бамбалзаад багачуул нэгнээс нөгөөд үсрэн
тоглодогсон. Манайхан “бамбалзуур” л гэдэг юм. Бамбалзуурын
хооронд унавал ч... дүүрэх нь тэр, намган дунд шигдээд өвдгөө хүртэл ч ус,
шавар болно шүү дээ. Харин дээр нь гараад үсрэхээр пуршин дээр л үсэрч байгаа
мэт зугаатай. Угтаа бол энэ нь доороо хөрс нь хөлдүү цэвдэгтэйн гэрч гэдгийг би хожуу
ойлгосон юм даг. Хөрсөн дэх ус өвлийн цагт хөлдөхөөрөө дээдэх газар нь овойдог тул бяцхан
довнууд үүсдэг. Зундаа дулаарахаар цэвдэг нь гэсэж “бамбалзуур” болдог юм билээ. Шил саванд
хийсэн ус хөлдөхөөрөө тэлж, шил нь хагардаг шүү дээ. Үүнтэй нэгэн адил гэдгийг багадаа нэг
их ойлгож явсангүй дээ үнэнийг хэлэхэд. Одоо юм юмны захыг ойлгоод ирэхийн цагт цэвдэгтэй
хөрс, намагтай газар бас л байгаль эхийн өгөөж юм даа. Учир нь, тэнд ус их агуулагддаг, энэ
хэмжээгээрээ ууршилт явагдаж агаарт чийг болон дэгддэг, тэр нь эргээд бороо хур болон бууж
ургамал ургахад “хоол тэжээл” болдог байна.

“Уур амьсгал хуурайшаад байгаа нь үнэн шүү. Заримдаа энэ нь мань мэтдээ тустай ч болсон уу гэмээр бодогдох юм. Манай сумын урдуур урсах голын баруун эрэг дагуу нэлдээ намаг байж билээ. Дээхэн үед бол морьтой хүн гаталдаггүй, бүр холуур тойрдог битүү намагтай хөндий байсан. Одоо тэр “намган” дунд айлууд зусаж байна. Өнгөрсөн зун би Улаанбаатар орж ахын зусланд очиход ч бас тийм байсан, намайг оюутан байхад Хандгайт орох замд явахын аргагүй, хөндлөн мод тавьж байж гардаг намагтай газар одоо бол хачин гоё гоё байшин барьсан харагдах чинь билээ. Намгийг хатаах гэж зарим газар их л хөрөнгө хүч ордог гэсэн. Гэтэл манайд...” гэж Дарам мэдэмхийрэв.



“Хүүхэд, энэ чинь л харин бидний ярианы гол сэдэв юм. Намаг хатаж байгаа бол тун муу хэрэг. Яагаад гэвэл намаг үүсэх нь хөрсөнд ус ихтэй, бүр илүүдэж байгаа хэрэг. Намгаас ууршсан ус агаарт хөөрөн гарч, эргээд хур тунадас болон буудаг. Хэрэв уурших ус нь байхгүй бол бороо орохгүй шүү дээ. Ингэхлээр намаг хатаж хуурайших нь бас л байгалийн тэнцвэр алдагдаж байгаагийн илрэл юм. Тэр дагуух намаг яагаад хатсан гэж бодож байна?” хэмээн Баяраа өдөв.

Мэдэмхийгээрээ Дарам л “бороо орохгүй болохоор л тэр шүү дээ” гэж байна. Хүмүүсийн ихэнх нь харцаа доошлуулан хариултаа олж ядаж байгаа нь илт ч, Дампил гуай тэндээс гарцыг олов.



“Манай энд малын хөл ихэдсээн. Малаа хаана яаж бэлчээрлүүлэх талаар бодохоосоо илүүтэй айл болгон л малаа өсгөхийг хичээж байна. Гэтэл Хар-Ус нуурын байгалийн цогцолборт газрыг хамгаалалтад авсан нэг шалтгаан нь ус намгийн шувуудын амьдрах орчныг бүрдүүлэх, нууруудын эргэн тойрны зэгс, шагшуургыг хамгаалах шүү дээ. Ач холбогдлоороо ийм ус намагтай газар бол халуун орны ойн дараа л ордог гэдгийм. Яагаад гэвэл, нуурын эргэн тойрны зэгс шагшуурга бол ус намгийн шувуудын амьдрах орчныг бүрдүүлдэг. Энд чинь хун, бор галуу, төрөл бүрийн цахлай, нугас, зуун хурга, хөх, цагаан дэглий, нэн ховордсон хотон зэрэг шувууд зусдаг. Мөн 200 гаруй зүйлийн нүүдлийн шувууд өндөглөн зусдаг. Тэдгээрийн дотор дэлхийд ховордож байгаа цөөнгүй шувууд байгаа гэдэг шүү. Ингэхлээр зөвхөн манай нутгаар ч зогсохгүй бүр Төв Азийн ус намгийн төлөөлөл болдгийм шүү дээ, энэ нутаг” гэж байна.

Араар суугаа залуучууд бүр гайхсан, хүндэлсэн өнгөөр ширтэн, зарим нь Дампил гуайн ярьсныг тэмдэглэн авч байгаа харагдана.

“За тэр харав уу? Зөвхөн ус агуулж, ууршилтад нэмэр болдог төдий биш байх нь. Намаг хатах юм бол тэр олон зүйлийн шувууд амьдардаг “орон”-гүй болно гэсэн үг байна шүү дээ.”

Бэлчээрийн менежмент гэж юу вэ?


“Сүүлийн үед бэлчээрийн менежмент гэж их ярих боллоо. Энэ нь юуг хэлээд байгаа юм бол оо?” хэмээх Долгорын асуулт бидний яриаг өөр зүгт хөтөллөө.

“Бэлчээрийн менежмент гэдэг нь бэлчээрт гаргах малын тохирсон тоо хэмжээг сонгоно гэсэн үг юм. Мөн бэлчээрийн даац гэж байна. Бид 5 тонны даацтай машинд 10 тонн ачаа ачвал юу болох вэ? Үүнтэй нэгэн адил тодорхой талбайд ургасан өвс ургамлын төрөл зүйл, гадаргын налуу, уснаас хэр хол байгаа зай зэрэг олон хүчин зүйлийг тооцсоны үндсэн дээр тэр талбайд бэлчээрлэх малын тоо толгойг тогтооно гэсэн үг юм л даа. Даац гэдэг нь ургамал, өвс ногоо, ус худаг зэрэгт гарз хохирол учруулахгүй хэмжээнд малыг өсгөх дээд хязгаар юм. Жишээ нь, нэг хонь жилд ойролцоогоор 540 кг өвс идэж байвал хэвийн хэмжээнд байна гэсэн үг.”



“За хонь тийм байдгийм байж. Тэгэхээр ямаа, тэмээ яахав? Манай муу хэдэн тэмээний норм ч арай их байж таарнаа даа” хэмээн нөгөө хулгар Ганбаа “магадалж” байна.

“Энэ зөв асуулт байна. Бүх малыг хонь толгойд шилжүүлж бодож болдог. Тухайлбал, нэг ямаа 0.9, үхэр 6, адуу 6.6, тэмээ 5.7 хонь толгойтой тэнцэнэ. Бэлчээрт ашигласан өвс ургамал дахин нөхөн ургадаг байх ёстой. Харин бэлчээрийг хэтрүүлэн хэрэглэсэн бол ургамлын үндэс нарийсан, өвсний гарц жил ирэх тутам муудна.”



“За тэр дээ. 30 жилийн өмнөхтэй харьцуулахад өвс ургамлын өндөр бараг 2 дахин багассан байх шүү, өвсний шим ч муудсан. Өвсний өндөр тэмээний гэдэс хүрдэг байлаа шүү дээ. Миний муу аав дээхэндээ өндөр өвсөн дунд уургаа алдчихаад олохгүй байсан гэдэг сэн” гэж Дампил гуай намайг дэмжлээ.

“Хөдөөний бидэндээ ямаа чинь ганц “саалийн үнээ” болж хувирсан шүү дээ. Орлогын ганц эх үүсвэр. Гэтэл сүүлийн үед бас ноолуурын үнэ ханш унаад байдаг. Уг нь ямаа ярвигтай амьтан л даа. Хариулж харахад ч амаргүй, хаа сайгүй гүйгээд л алга болчихно. Бас тэгээд өвсний үндсийг ухаж идэхийг нь яанаа. Хажууд нь хөөрхий хонь бол тогтуун сайхаан. Гэвч мөнгө цагаан, нүд улаан болсон өнөө үед бид чинь яалтай билээ” гэж Долгор бувгналаа.

“Өнөөдрийн өөхнөөс маргаашийн уушиг” гэдэг үг бий шүү дээ! Тэгэхлээр өнөөдөр олж байгаа хэдэн төгрөгөө бодож ямаагаа хэт өсгөснөөс цөөн боловч чанартай мал өсгөж сүргийн бүтцийг зөв хадгалах талаар гараад байгаа яриа ухуулгыг манайхан эрх биш ойлгох цаг болсон баймаар” Дампил гуайн дуу бусдын анхаарлыг татаж хэлэв.



Сүргийн бүтцээ зохистой харьцаанд барина гэдэг нь бэлчээрийн талхагдлаас сэргийлэх, өвс ч ургамал ургах, ус нутгаа хамгаалах, яван явсаар өнөө л уур амьсгалын өөрчлөлтөд бидний оруулж чадах хувь нэмэр юм даа” гэсээр бидний яриа улам л өрнөв.

ТАТМЫН ОЙ ЯМАР АЧ ХОЛБОГДОЛТОЙ ВЭ?



“Тол нуурын эрэг орчмын намгийн ач холбогдлын талаар мэдэж авлаа. Гэтэл намаг байхгүй голын татамд олон төрлийн мод ургасан ой бий. Үүнийг татмын ой гэж нэрлэдэг. Манай нутгийн голын татмын ой хэр “баян” вэ? Миний асуулт хүмүүсийн жинхэнэ “загатнасан газар маажив” бололтой. Бүгд л ам уралдан ярьж эхэллээ.



“Манай энэ хавьд бол голын татмаараа улиас, бургас л голдуу байдаг даа.”



“Голын татмын ойд жимс жимсгэний мод бут, хүнс тэжээлд өргөн хэрэглэдэг ургамлууд зонхилон ургадаг.”



“Голын татамд олон төрлийн шувууд, бусад амьтад амьдардаг. Тэгэхлээр татмын ой бол бас л чухал амьдрах орчин.”



Татмын ой бол усны урсацыг тэтгэдэг. Мөн хөрсний элэгдлийг хязгаарлахад чухал үүрэгтэй...” гэх мэтээр ярьцгаалаа.

Дампил гуай ихэд сэтгэл хангалуун над руу харлаа. Аргагүй ээ, голын сав газрынхны ажил үр дүнд хүрчээ. Түүнчлэн голын татмын ой багасаж, ус татрах болсны шалтгааныг ч сайн мэдэж байлаа.

Татмын ой усыг тогтоон барьснаар голын усны түвшин хэвийн хэмжээнд байхад нөлөөлнө. Мөн модны үндэс нь хөрсийг сийрэгжүүлж, бусад ургамлын ургах нөхцлийг дэмжиж байдаг. Иймд татмын ой хатах нь голын усны түвшин багасгахад хүргэнэ. Мод, ургамал усыг тогтоон барьдаг гэдгийг бид олон удаа сонсож байсан. Гэвч ний нуугүй хэлэхэд тэгтлээ ч сайн ухаардаггүй шүү дээ.



Энгийнээр нэг жишээ авъя л даа. Нэлээд устай бороо орлоо гэж бодъё. Борооны дараа харахад ямар газар ус их тогтсон, ямар газар нь ус “алга болсон” байдаг вэ?

Ургамал ургаагүй хад чулуу, хайрга ч юмуу ургамал нь халцарсан машин зам дээр дагаад л ус тогтож, бүр заримдаа урсаад замаа эвдэх нь олонтаа. Харин замын хажуугийн өвсөн дотор болохоор ус тогтдоггүй, дорхноо шингээд л алга болдог. Гандаж хатсан өвс ногоо усыг жинхэнэдээ “уудаг” болохоор тэр шүү. Ингэснээр өвс модтой газрын хөрсөнд шингэсэн ус бороо орохгүй байсан ч эргээд удаан хугацаанд ургамлын шим тэжээл болдог учиртай юм.

Эндээс та бүхэн татмын ойн ач холбогдлын талаар сайн ойлгож авсан байх аа. Хүмүүс бүгд толгой дохив. Ингэхлээр татмын ойг хамгаалах шаардлагатай гэдэг нь харагдаж байна.

Харин хэрхэн яаж хамгаалах вэ!

“Татмын ойг хамгаалах арга нь ойн хортон шавж үржихээс сэргийлэх явдал юм. Ой модны заналт дайсан болох хортон шавжийн тоонд төрөл бүрийн эрвээхэй ордог.”

“Эрвээхэй гэнээ, арай үгүй байлгүй дээ, тэд чинь цэцэг дамжин нисэж тоос хүртээдэг, ингэснээр ургамал ургахад маш хэрэгтэй гэж сургуульд байхад биологийн хичээлээр үзсэн шүү дээ!”



“Тийм ээ. Цэцгийн балаар ургамалд тоос хүртээж байгальд “буян” үйлддэг эрвээхэй бий. Гэхдээ бүгд энэ төрөлд ордоггүй нь харамсалтай. Жишээ нь, та нар “бүгэг” эрвээхэйг мэднэ дээ. Тэд өдрийн цагаар өвс ургамал дор нуугдаж шөнө нь идэш тэжээлийнхээ эрэлд гардаг. Ингэж бүгэн нуугддаг учраас бүгэг хэмээх нэр авчээ. Монголчуудын нэрлэдгээр дэнгийн эрвээхэй энэ юм.”

“Аан дэнгийн эрвээхэйг мэдэлгүй дээ, “бүгэг” гэсэн нэрээр бол мэдэхгүй юм байна. Тэгвэл энэ чинь үслэггүй махлаг биетэй шүү дээ.”

“За тэр зөв дөө. Дотроо олон янз. Манай оронд 130 гаруй зүйл бий. Эдгээрийн дийлэнх нь ургамлын үндэс болон дээд хэсгийг нь мэрдэг. Ямар ч ургамлаар хооллодог.”



Ой модны дайсан болох өөр ч бас олон төрлийн эрвээхэй бий. Жишээ нь, Сибирийн хүр, өрөөсгөл хүр, шилмүүс хуйлагч, яacobсоны төөлүүр гээд л, бүгд модны дайсан шүү дээ. Эдгээрийг бусдаас ялган таньж ядах юмгүй. Далавчных нь судлаар танина. Жишээ нь, өрөөсгөл хүр эрвээхэй бол далавчных нь өнгө хүрэн, түүн дээрээ хөндлөн арай тод хүрэн судалтай. Өрөөсгөл хүр эрвээхэйн хүрэнцэр их хөнөөлтэй. (зураг 1)

Сибирийн хүр эрвээхэйн хүрэнцэр модны мөчрийг даган төөлүүр хорхой шиг наалдаад л модыг мэрж эхэлдэг. (зураг 2) Хүрэнцрийн өндөг нь ургамлын иш мөчир дээр наалдсан байдаг. Ийм үед нь модны мөчрөөс салгавал ажил арай бага орно.

Бургасны долгиот эрвээхэй их элбэг бөгөөд татмын ойг хатахад их “үүрэг гүйцэтгэдэг”. Ялангуяа Сибирийн хүр эрвээхэйд олон дахин давтан идүүлсэн ой хатаж, дахин сэргэх боломжгүйгээр устаж үгүй болоход хүрдэг. Хэрэв ингэж хатсан бол модыг аж ахуйд ашиглахаас өөр замгүй. Харин оронд нь ойжуулах хэрэгтэй.

Ой модыг идэгч дээрх төрлийн эрвээхэй олширч байгаа нь цаг агаар хуурайшихтай холбоотой. Иймд татмын ойг хамгаалж байгалийн тэнцвэрийг хэвээр хадгалж чадвал эдгээр хөнөөлт шавж олшрохоос сэргийлж чадна.



Зураг 1. Өрөөсгөл хүр эрвээхэй



Зураг 2. а. Сибирийн хүр эрвээхэйн хүрэнцэр, б. Сибирийн хүр эрвээхэйн өндөг



Бид дараах үйлдлүүдийг зогсоож чадвал татмын ойг хатаж, багасгахаас хамгаалж чадна. Үүнд:

- Голын татмын ойд өвөлжөө, хаваржаа, хашаа хороо барихыг зогсоох;
- Жил дараалан мал бэлчээж талхилах нь татмын ойг дахин сэргэхгүйд хүргэдгийг анхаарах;
- Татмын мод бутыг огтлохгүй байх, голын бургасыг түлшинд хэрэглэхийг хориглох;
- Зуны цагт гаднын аялагчид дурын газар отоглодог, хог хаядаг, замбараагүй зам гаргаж хөрсийг эвдрэлд оруулдаг тул нутгийн иргэд болон сав гарын зөвлөлөөс хяналт тавих,
- Нутгийн болон гаднын жимсчид жимс ихээр түүж мод бут хугалдаг тул нутгийн хүн бүр “байгаль хамгаалагч” байх;
- Татмын ойд түймэр тавихаас сэргийлж ил задгай гал түлэхгүй байх;
- Ойн дагалдах баялаг, ан амьтантай зүй зохистой харьцах.

ЗАГ ЗАНДАНГААС ҮНЭТЭЙ

Бидний яриа сүүлдээ олон сэдвийг хөндөсний дотор элсний нүүдэл, цөлжилтийн талаар байв.



“Сумын төвөөр явахдаа та ажигласан уу, айлуудын хашааны арыг элс бүрхээд байшингийн орой руу “алхаад” гарч болдог болсон. Эмнэлгийн зарим өрөөний цонх элсэнд бараг хучигдаад дотор нь ороход харанхуй юм шиг л бүүдийсэн юм билээ. Сүүлийн үед байгаль эх нээрээ бидэнд их “ширүүлж” байна. Одоо бид чинь сумын төвөө нүүлгэхээс өөр зам байхгүй гэж яриад байгаа шүү дээ. Олон жил байсан суусан газраасаа хөдөлнө гэхээр сэтгэлд багтахгүй байна, ямар их ажил, хөрөнгө мөнгө орохыг та төсөөлж байна уу?”



Хүмүүсийн ярианаас үзвэл байгаль эхийн буруугаар л элсний нүүдэл ихсэж, маньдаа хүндрэл “учруулж” байгаа гэнэ. Угтаа бол элсний нүүдэлд байгалийн буруу бараг үгүй. Хүмүүс бид л халтай хандсанаас болж байгаа юм.

Ингэж бодоод би асуулаа “Сая хөдөөгүүр явахад аргал элбэгшжээ. Бага байхад аргал түүх гэдэг зугаатай ч шуудайгаа дүүргэхэд бас л амаргүй ажил байж билээ. Тэр болгон аргал олдохгүй, ялангуяа ажилсаг айлын ойролцоо бол бүр юу ч үгүй цэвэрхэн. Би л лав аргал түлэхээргүйгээр уур амьсгал “дулаарсан” гэж бодохгүй байна. Тээр холоос нүүрс зөөж ирэх гэхээр унаа унаш гээд бас хэцүү...” гээд ярьж эхэлтэл мэдэмхий Дамба “Одоо аргал түлнэ гэдэг амар ажил биш ээ, аргал түүнэ гэдэг ёстой хэцүү ажил, байгаль эх бидэнд заг гэж бэлэн түлээ бэлдээд өгсөн байхад. Заг тэгээд илчтэйг яана. Эгээ л нүүрс гэсэн үг. Манайхан чинь үхрийн баасаа ч хатаахаа больсон шүү дээ, нутгийнхаа буянаар...” гэж яриаг минь таслав.

“Аа за заг түлдэг байх нь. Энд бас нэг шинэ сэдэв гараад ирлээ.” ...



“Дулмаа Дамбыг нүдээрээ шилбүүрдсэнээ Энэ Дамба одоо заг түүж түлэхээ л мэдэхээс биш, тариалахыг мэдэхгүй л дээ”

Дампил гуай ууртайгаар За тэр харав уу хүүхэд. Хөгшин бид хоёр хүртэл хаа холоос аргал цуглуулах гэж ядаж байхад залуу улсууд ийм л залхуу байгаа юм даа. Цагаан гоёо гэж мөн ч сайхан юм байж билээ, амттайг яана. Гэтэл заг ховордсоноос болоод сүүлийн үед бүр харагдахаа байсан. Цагаан гоёо чинь заг ихтэй газар л ургадаг эд шүү дээ. Ингээд л бид байгалиа өөрсдөө сүйтгээд байгаа юм даа...



“Тэр ч харин үнэн шүү. Тариалах аргыг нь заагаад өгвөл болохгүй нь юу байхав дээ” хэмээн нэлээд зөөлөрсөн аясаар өгүүлэв.

За ингээд “Заг тариалах арга”-тай танилцацагаая гээд би бэлтгэсэн материалаа тараалаа. Уншигч та ч бидэнтэй хамт заг тариалах аргыг судлаарай.

Хүмүүс нэлээд нухацтай уншиж, хоорондоо ярьж байгаа харагдана. Дараа нь Дампил гуай санал гаргав. “За хүүхэд... зандан эрдэнэ болсон загийгаа бид “аварч” болох нь байна ш дээ.

Нэг нутаг усны хэрэг юу билээ, хэдүүлээ нийлж заг тариалъя, залуучууддаа ч зааж өгье. Наана чинь сумын төвөөр дүүрэн хийх юмгүй холхисон сайхан залуус байна ш дээ. Тэдэнд заагаад өгвөл ч....Энэ сайхан хүүхдүүд хөдөлмөрийн амтыг мэдрээд, тарьсан мод нь ургаад ирэхийн алдад ингэж дэмий өдөр өнгөрөөхөө болино шүү дээ. Та нар харж л байгаарай” гэв.

Бүгдээрээ Дампил гуайн саналыг дэмжлээ. Дампил гуай ч “дүрдээ итгээд” явчихав болтой, хэн юу хийх талаар зааварчилж гарлаа.



Заг тариалах арга

Заг 4 дүгээр сарын сүүл, 5 дугаар сарын эхээр ургаж эхэлдэг. 5 дугаар сарын дундуур цэцэглэж эхэлдэг.

Загийн үрийг хэзээ түүх вэ?

10 дугаар сарын эхний хагаст үр нь боловсорч дуусдаг. Загийн үрийг далавчных нь хамтаар “замбага” гэдэг. Загийн үр хэлбэржин шаргалтаж, хөврөл нь бор ногоон өнгөтэй, имэрч үзэхэд шүүсгүй болж хатуурсан байвал үр боловсорч дууссаныг гэрчилнэ. Загийн үрийг 10 дугаар сарын дундаас 11 дүгээр сарын дунд хүртэл түүхэд тохиромжтой.


Загийн үрийг хэрхэн түүх вэ?

- ❖ Заг модны ишийг тойруулан томхон хэмжээтэй (3-4 м) бөс даавуу дэвснэ.
- ❖ Иш мөчрийг нь хугалалгүйгээр модыг нийтэд нь хөдөлгөн сэгсрэх юмуу, нарийн саваагаар зөөлөн цохиход боловсорсон замбага даавуун дээр унана.
- ❖ Замбагыг 10-15 см зузаан үе болгон дэлгэж сэврээн гараар атгахад чийг мэдрэгдэхгүй болтол нь хатаана.
- ❖ Холилдон унасан мөчир салмайгаас нь цэвэрлэн савлана.
- ❖ Савтай замбагыг чийгтэй, агаар сайтай байранд хадгална. Хадгалах үедээ заавал цэвэрлэсэн байх шаардлагатай. Нэг жил хүртэл хадгалах бол нийлэг хальсан уутанд хийж болно. 2-3 жил хадгалахаар бол шилэн саванд хийх нь тустай.



Хэрхэн тариалах вэ?

- Загийн үрийг тарих газар нь хөнгөн сийрэг бүтэц бүхий элсэнцэр хөрстэй байна.
- Тариалах талбайг 25-30 см гүн хагалж, борнойдох юмуу эсвэл гар багажаар боловсруулж зөөлрүүлнэ.
- Тариалахдаа 10 см өргөнтэй хоёр мөр гаргаж туузална.
- Нэг метр тутамд гурван грамм үрийг 0.5-1 см гүнд суулгана.
- Элсэрхэг хөнгөн хөрсөнд суулгасан үрийг бүрэн соёолтол шүршүүрээр зөөлөн усална. Загийн үрийн хальс 36 цагийн дотор дэвтэж тэнийнэ. Нэгэнт дэвтэж тэнийсэн хөврөл хатвал дахин соёолдоггүй учир үрийг бүрэн соёолж дуусах хүртэл хөрсний өнгөн гадаргууг хатааж болохгүй. Соёололт жигдэрснээс хойш усалгааг өдөр өнжүүлж болно.
- Ургах хугацаанд зэрлэг ургамлыг 2-3 удаа устгахаас гадна хөрсийг сийрэгжүүлнэ.
- Эхний 4-5 жил малаас хамгаалах шаардлагатай.
- 1 га талбайд 700-750 шоо метр усаар анхны усалгааг хийнэ.
- Дараа нь соёололт жигдрэх хүртэл 14 хоногийн хугацаанд өдөр бүр 150-200 шоо метр усаар 2 удаа усалж өгвөл ургалт түргэсдэг байна. Ийм аргаар элсний нүүдлийг зогсоож цөлжилттэй тэмцэх боломжтой ажээ.
- 10 дугаар сарын дунд үеэс эхлэн 20 хоногийн хугацаанд нэг га талбайгаас 100-150 килограмм загийн үр түүх боломжтой.



Өнтэй зун заган ойг үрээр тариалахад сайн байдаг. Цулгуй элсэнд ч тариалж болох ба үр тарихын өмнө тармуураар өнгөн хэсгийг нь сийрүүлнэ. Бэлтгэсэн талбайд үрийг жигд цацаж, борнойдох юмуу дахин тармаж үрийг элстэй хольж далдална. Харин гантай жил юмуу хуурай үед элсэнд үр цацвал үр дүнгүй болдог.

Үрээр үржүүлсэн 6 хүртэлх насны загийг шилжүүлэн суулгаж болно.

Бэлчээрийг хамгаалах, ургацыг нэмэгдүүлэх зорилгоор заган ойг зурваслан тарьж болно. Энэ зурвас нь хоорондоо 3 метр зайтай, тус бүрдээ 3 эгнээ байх нь тохиромжтой.


МОД ДАГАЖ УС, УС ДАГАЖ АМЬДРАЛ

“Муу найз минь чи нутагтаа
буян үйлдлээ шүү, угаасан
ус, унасан газар чинь чамд
баярлана даа!”

Нутагтаа өнгөрүүлсэн хэд хоног
харвасан сум шиг өнгөрч миний
явах цаг ч тулжээ. Буцахын урд
орой Долгорындоо дахин нэг хонож
нөгөө л хэзээний дуусдаггүй хуучаа
хөөрлөө. Энэ удаад бид хоёрын яриа
анхныхыг бодвол өөр аястай болсон нь
анзаарагдав. Долгор хэлж байна:

“Юуны төлөө намайгаа хэт
үнэлж байгаа билээ дээ, би
одоо суварга энэ тэр босгож,
ном гүрэм хуруулаагүй л
юм сан.”

“Үгүй ээ, Бат минь чи бидэнд болохоосоо болохгүй нь их
гэх болсон энэ нутагтаа аятай амьдрах арга зааж, биднийхээ
нүдийг нээж өгнөө гэдэг чинь буян биш гэж үү. Гэтэл пүүс
компани гээд хөрөнгө мөнгөтэй болсон нутгийн улс яаж
байна, харин ч эсрэгээрээ. Бид хэдийгээр өнгө мөнгөөр
хуурсхийж байгаад л алтыг нь ухна. “Хөөрхий нутгийн хүү”
гээд хүмүүс ч хөөж тууж чадахгүй. Эсвэл нэг их суварга
босгоод л найр наадам хийнэ. Тэр нь ямар бороо оруулах
биш дээ. Тэрний хажууд миний найзынх бол буяан буян”



“Би юу ойлгож мэдсэнээ хэлье л дээ.” гээд ажил хэрэгч царай гарган хуруу даран өгүүлж гарлаа.

Нэгдүгээрт, уур амьсгал өөрчлөгдөөд болохоо байлаа гээд хий гаслаад суумааргүй юм байна.

Хоёрт, гол ус бол бусад бүх зүйлтэйгээ амин хэлхээтэй болохоор

Гуравт, бид өөрсдөө ахуй амьдралаа зөв авч явах хэрэгтэй юм байна. Жишээ нь: Бид зурагтаа дутуу унтраагаад л орхидог юм байна шүүдээ, за энэ яаж байна, нөгөө л хүлэмжийн хийг л ихэсгээд байна. Машин мотоциклээр малдаа явж байна. Энэ яаж байна? Ингэж бензин шатахуун үрж агаар бохирдуулж байснаас морь тэмээгээ хэрэглээд, явган яваад өөрсдөө ч хөдөлгөөнтэй эрүүл байхад ч тустай.

Дөрөвт, намгийн ач тусыг ухаарлаа. Тэндээс ус ууршин үүл болж байж л бороо хур ордог юм байна шүү дээ. Мод ургамал идэж сүйд хийдэг эрвээхэйг ч танихтайгаа боллоо.



Тавд, цөөн чанартай мал өсгөөд л бэлчээрээ гамнах нь олноосоо илүү ашигтай гэдгийг мэдэж авлаа. Манайхан л “мянгат, мянгат” гээд сүйд болоод байдаг чинь угтаа бол буруу юм байна шүү дээ.

Зургаад, би л лав үүнээс хойш, түүнээс цааш голын татмаас мод бут авахаа болино. Хүүхдүүддээ ч хэлж зааж өгнө гэдгээ ойлголоо.

Долоод, гээд хуруугаа нугалснаа бодолхийлэн:
- Аан тийм, заг байна. За энэ тухай бол манайхан маш сайн ойлгосоон. Заг тариалах тал дээр бол би ч багшилчихна шүү. Дампил гуайгаас юу нь дутахав дээ гэв. Дампил гуай гэснээс бид бүгдээрээ л гол усаа хамгаалах, залуу үеийнхэндээ зааж сургахад оролцож баймаар юм байна шүү дээ. Ингэхэд би нээрээ өдий болтол юугаа хийж явсан юм бол доо.

Долгорын яриаг сонсоод сэтгэл нэг л уужирсан мэт урт амьсгаа авч, тооноор харахад одод гялалзан хачин цэлмэг шөнө болж байгааг илтгэнэ. Манай голынхон шиг хиртээгүй сайхан сэтгэлтэй малчин ардууддаа бүгдэд нь тус болохсон гэсэн гэнэхэн бодолдоо хөтлөгдсөөр би хөдөөгийн цэнгэг агаарт цохиулан нам унтчихжээ.

